



**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар ХТ-25/01

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11.9 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “Сайн” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР



**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар ХЗ-25/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг хавсралтын дагуу нийт 245,000,000.00 (Хоёр зуун дөчин таван сая) төгрөгөөр баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

О.ОДБАЯР



“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
 ээлжит хурлын 2025 оны 01 сарын 25 өдрийн
 ХТ-25 дугаар тогтоолын хавсралт



“Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
 2025 оны зардлын төсөв

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал /мян.төг/	Сар	Нийт /мян.төг/
1. Цалингийн зардал					
1	ТУЗ-ийн дарга	1	1,800.0	12	21,600.0
2	Хорооны дарга	3	1,680.0	12	60,480.0
3	Гишүүд	5	1,560.0	12	93,600.0
4	Н/б-ийн дарга	1	1,560.0	12	18,720.0
5	НДШ /12%/			12	23,100.0
Дүн					217,500.0
2. Бичиг хэрэг, хангамж болон бусад зардал					
7	Бичиг хэрэг, хангамжийн зардал				2,500.0
9	Томилолтын зардал				25,000.0
Дүн					27,500.0
НИЙТ ЗАРДАЛ					245,000.0



**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар ХЗ - 25/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

2. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг тус тус 2 жилийн хугацаатайгаар сонгосугай.

2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 2.1.1 Монгол Улсын иргэн Даваахүү овогтой Нарангэрэл
- 2.1.2 Монгол Улсын иргэн Даваасамба овогтой Дэлгэрмаа
- 2.1.3 Монгол Улсын иргэн Даваадорж овогтой Балжинням
- 2.1.4 Монгол Улсын иргэн Хаш-Эрдэнэ овогтой Сүрэнхорол
- 2.1.5 Монгол Улсын иргэн Одончимэд овогтой Одбаяр
- 2.1.6 Монгол Улсын иргэн Галням овогтой Уянга

2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 2.2.1 Монгол Улсын иргэн Банзрагч овогтой Ганбаатар
- 2.2.2 Монгол Улсын иргэн Дарамбазар овогтой Балдорж
- 2.2.3 Монгол Улсын иргэн Чүлтэм овогтой Амарбаатар

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР